



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/093/НА-СТА-ТШЗ**

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a><br/>Сүхбаатар сум<br/>2026 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх<br/>Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn<br/>Ахлах аудитор: Ц.Отгонбаяр<br/>Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn<br/>Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар<br/>Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № СЭА-2026/093/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МАНДАЛ СУМЫН ТҮНХЭЛ  
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Д.ЭНХТУЯА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Боловсролын ерөнхий газраас 8,321.4 мянган төгрөгийн ангийн самбар, ном сурах бичгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Мандал сумын ИТХ-ын 2025 оны 34 дүгээр тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 45,527.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хасагдуулсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс  | Балансын зүйл   | Тодруулга | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  |
|-------|---|-----------|------------------|------------------|
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 4         | 204,736,591.84   | 218,927,834.48   |
| 312   | Банкинд байгаа бэлэн мөнгө  |           | 204,736,591.84   | 218,927,834.48   |
| 3121  | Төгрөг  |           | 204,736,591.84   | 218,927,834.48   |
| 31211 | Төрийн сангийн харилцах   |           | 204,736,591.84   | 218,927,834.48   |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ  | 6         | 8,226,397.40     | 23,848,115.00    |
| 351   | Түүхий эд материал  |           | 6,159,842.40     | 1,774,660.00     |
| 3511  | Тусгай зориулалттай материал  |           | 5,959,842.40     | 1,681,500.00     |
| 3513  | Эм боох материал  |           | 200,000.00       | 93,160.00        |
| 354   | Хангамжийн материал   |           | 2,066,555.00     | 22,073,455.00    |
| 3541  | Бичиг хэргийн материал  |           | 277,500.00       | 869,900.00       |
| 3542  | Аж ахуйн материал   |           | 1,132,600.00     | 1,699,000.00     |
| 3545  | Барилгын засварын материал  |           |                  | 18,996,100.00    |
| 3547  | Бусад хангамжийн материал   |           | 656,455.00       | 508,455.00       |
| I     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   |           | 212,962,989.24   | 242,775,949.48   |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 7         | 1,105,855,973.38 | 1,026,820,883.16 |
| 392   | Биет хөрөнгө  |           | 1,068,241,399.66 | 989,226,184.44   |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц  |           | 809,053,829.25   | 809,053,829.25   |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (177,617,447.67) | (224,485,320.03) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл  |           | 14,562,500.00    | 14,562,500.00    |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (14,441,145.83)  | (14,441,145.83)  |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     |           | 453,546,654.09   | 444,711,295.64   |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (183,109,862.58) | (204,869,494.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил   |           | 141,974,119.15   | 156,467,814.15   |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (67,639,387.55)  | (84,721,046.55)  |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө  |           | 74,228,105.00    | 74,228,105.00    |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (33,120,576.27)  | (39,006,392.36)  |
| 39217 | Ном   |           | 50,804,612.07    | 57,726,039.83    |
| 393   | Биет бус хөрөнгө  |           | 37,614,573.72    | 37,594,698.72    |
| 39301 | Програм хангамж   |           | 318,000.00       | 318,000.00       |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл   |           | (203,426.28)     | (223,301.28)     |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө  |           | 37,500,000.00    | 37,500,000.00    |
| II    | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   |           | 1,105,855,973.38 | 1,026,820,883.16 |
| III   | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   |           | 1,318,818,962.62 | 1,269,596,832.64 |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 9         | 171,600.05       |                  |
| 413   | Өглөг   |           | 171,600.05       |                  |
| 4131  | Ажилчидтай холбогдсон өглөг   |           | 171,600.05       |                  |
| IV    | НИЙТ ӨР ТӨЛБӨР  |           | 171,600.05       |                  |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо   |           | 1,318,647,362.57 | 1,269,596,832.64 |
| 511   | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан |           | 407,571,022.70   | 407,571,022.70   |
| 51101 | Өмч: - төрийн   |           | 407,571,022.70   | 407,571,022.70   |
| 512   | Хуримтлагдсан үр дүн  |           | 530,498,662.35   | 481,448,132.42   |
| 5121  | Өмнөх үеийн үр дүн  |           | 530,498,662.35   | 530,498,662.35   |
| 5122  | Тайлант үеийн үр дүн  |           |                  | (49,050,529.93)  |
| 513   | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      |           | 380,577,677.52   | 380,577,677.52   |
| V     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  |           | 1,318,647,362.57 | 1,269,596,832.64 |
| VI    | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           |           | 1,318,818,962.62 | 1,269,596,832.64 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс    | Үзүүлэлт   | Тодруулга | Өмнөх он         | Тайлант он       |
|---------|--|-----------|------------------|------------------|
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  |           | 1,894,652,867.08 | 2,178,067,360.09 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  |           | 1,802,951,400.00 | 2,039,296,400.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    |           | 1,802,951,400.00 | 2,039,296,400.00 |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       |           | 91,701,467.08    | 138,770,960.09   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  |           | 91,701,467.08    | 138,770,960.09   |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  |           | 135,881,862.70   | 19,923,207.76    |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  |           | 135,881,862.70   | 19,923,207.76    |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     |           | 5,869,600.00     | 5,228,300.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |           |                  | 5,228,300.00     |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |           | 200,000.00       |                  |
| 120009  | Бусад орлого   |           | 200,000.00       | 2,220,980.00     |
| 120017  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө                   |           | 125,687,820.30   | 8,321,427.76     |
| 120018  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал                   |           | 4,124,442.40     | 4,152,500.00     |
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                      | 2         | 2,030,534,729.78 | 2,197,990,567.85 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  |           | 1,914,537,711.21 | 2,247,041,097.78 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      |           | 1,825,222,201.21 | 2,144,030,247.78 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    |           | 1,338,309,402.53 | 1,594,387,276.42 |
| 210101  | Үндсэн цалин   |           | 879,264,885.06   | 951,902,520.99   |
| 210102  | Нэмэгдэл   |           | 395,136,114.42   | 540,233,973.88   |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт  |           |                  | 40,625,000.00    |
| 210104  | Урамшуулал   |           | 63,908,403.05    | 61,625,781.55    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       |           | 164,902,356.06   | 190,952,207.96   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   |           | 113,299,093.30   | 129,289,840.56   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   |           | 13,648,193.64    | 16,225,218.80    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  |           | 6,794,396.80     | 8,025,489.46     |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   |           | 6,232,074.47     | 7,370,998.98     |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  |           | 24,928,597.85    | 30,040,660.16    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            |           | 81,808,867.08    | 114,770,960.09   |
| 210301  | Гэрэл, цахилгаан   |           | 8,644,966.20     | 10,288,084.02    |
| 210302  | Түлш, халаалт  |           | 69,627,570.88    | 101,180,176.07   |
| 210303  | Цэвэр, бохир ус  |           | 3,536,330.00     | 3,302,700.00     |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    |           | 9,899,600.00     | 5,003,900.00     |
| 210604  | Урсгал засвар  |           | 9,899,600.00     | 5,003,900.00     |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             |           | 29,569,308.43    | 43,311,807.93    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |           | 3,473,400.00     | 5,228,300.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      |           | 26,095,908.43    | 38,083,507.93    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      |           | 200,732,667.11   | 195,604,095.38   |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      |           | 67,519,753.01    | 44,306,462.40    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    |           | 18,403,400.00    | 14,155,720.00    |
| 210903  | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   |           | 114,809,514.10   | 137,141,912.98   |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   |           | 89,315,510.00    | 103,010,850.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   |           | 89,315,510.00    | 103,010,850.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             |           | 62,620,310.00    | 103,010,850.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              |           | 26,695,200.00    |                  |
| II      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН  | 3         | 1,914,537,711.21 | 2,247,041,097.78 |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)                                   |           | 115,997,018.57   | (49,050,529.93)  |
| IV      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)                             |           |                  |                  |
| V       | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)  |           | 115,997,018.57   | (49,050,529.93)  |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Данс    | Үзүүлэлт   | Өмнөх он         | Тайлант он       |
|---------|--|------------------|------------------|
| I       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)                               | 1,900,522,467.08 | 2,185,516,640.09 |
| 12      | ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 5,869,600.00     | 7,449,280.00     |
| 120     | Нийтлэг татварын бус орлого  | 5,869,600.00     | 7,449,280.00     |
| 120004  | Төсөв байгууллагын өөрийн орлого                                     | 5,669,600.00     | 5,228,300.00     |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            |                  | 5,228,300.00     |
| 120009  | Бусад орлого   | 200,000.00       | 2,220,980.00     |
| 13      | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО  | 1,894,652,867.08 | 2,178,067,360.09 |
| 1310    | Улсын төвлөрсөн төсвөөс  | 1,802,951,400.00 | 2,039,296,400.00 |
| 131001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    | 1,802,951,400.00 | 2,039,296,400.00 |
| 1320    | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                       | 91,701,467.08    | 138,770,960.09   |
| 132001  | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 91,701,467.08    | 138,770,960.09   |
| II      | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)                                | 1,784,273,821.89 | 2,121,540,002.45 |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ  | 1,784,273,821.89 | 2,121,540,002.45 |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                      | 1,699,368,661.89 | 2,018,529,152.45 |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                    | 1,338,216,730.37 | 1,594,558,876.47 |
| 210101  | Үндсэн цалин   | 879,172,212.90   | 952,074,121.04   |
| 210102  | Нэмэгдэл   | 395,136,114.42   | 540,233,973.88   |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт  |                  | 40,625,000.00    |
| 210104  | Урамшуулал   | 63,908,403.05    | 61,625,781.55    |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 164,730,756.01   | 190,952,207.96   |
| 210201  | Тэтгэврийн даатгал   | 114,195,499.58   | 129,289,840.56   |
| 210202  | Тэтгэмжийн даатгал   | 12,580,187.31    | 16,225,218.80    |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал  | 6,794,396.80     | 8,025,489.46     |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал   | 6,232,074.47     | 7,370,998.98     |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал  | 24,928,597.85    | 30,040,660.16    |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 81,808,867.08    | 114,770,960.09   |
| 210301  | Гэрэл, цахилгаан   | 8,644,966.20     | 10,288,084.02    |
| 210302  | Түлш, халаалт  | 69,627,570.88    | 101,180,176.07   |
| 210303  | Цэвэр, бохир ус  | 3,536,330.00     | 3,302,700.00     |
| 2106    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 9,892,600.00     | 24,000,000.00    |
| 210604  | Урсгал засвар  | 9,892,600.00     | 24,000,000.00    |
| 2108    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 34,329,708.43    | 43,311,807.93    |
| 210801  | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,669,600.00     | 5,228,300.00     |
| 210806  | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 28,660,108.43    | 38,083,507.93    |
| 2109    | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 70,390,000.00    | 50,935,300.00    |
| 210901  | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 54,452,800.00    | 37,179,500.00    |
| 210902  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 15,937,200.00    | 13,755,800.00    |
| 213     | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 84,905,160.00    | 103,010,850.00   |
| 2132    | Бусад урсгал шилжүүлэг   | 84,905,160.00    | 103,010,850.00   |
| 213205  | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 59,007,360.00    | 103,010,850.00   |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 25,897,800.00    |                  |
| III     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                     | 116,248,645.19   | 63,976,637.64    |
| IV      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)                            |                  |                  |
| V       | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                            | 34,100,793.00    | 49,785,395.00    |
|         | Дотоод эх үүсвэрээр  | 34,100,793.00    | 49,785,395.00    |
| 222001  | Тоног төхөөрөмж  | 34,100,793.00    | 37,390,000.00    |
| 223001  | Бусад хөрөнгө  |                  | 12,395,395.00    |
| VI      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)  | (34,100,793.00)  | (49,785,395.00)  |
| VII     | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                      |                  |                  |
| VIII    | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                            | 82,147,852.19    | 14,191,242.64    |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                  | 204,736,591.84   |
| 31      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    |                  | 218,927,834.48   |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт   | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн  | Нийт дүн                |
|-----|--|-----------------------------|---------------------------|-----------------------|-------------------------|
| 10  | <b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>407,571,022.70</b>       | <b>380,577,677.52</b>     | <b>530,498,662.35</b> | <b>1,318,647,362.57</b> |
| 11  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                             |                           |                       |                         |
| 12  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       |                             |                           |                       |                         |
| 13  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт |                             |                           |                       |                         |
| 14  | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  |                             |                           |                       |                         |
| 15  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                             |                           |                       |                         |
| 16  | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               |                             |                           |                       |                         |
| 17  | Тайлант үеийн үр дүн                             |                             |                           | (49,050,529.93)       | (49,050,529.93)         |
| 19  | <b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>407,571,022.70</b>       | <b>380,577,677.52</b>     | <b>481,448,132.42</b> | <b>1,269,596,832.64</b> |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д     | Үзүүлэлт                                       | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү дүн       | Хувь  |
|---------|--|------------------|------------------|-----------------|-------|
| 1       | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО                    | 2,404,649,100.00 | 2,178,067,360.09 | 226,581,739.91  | 90.6  |
| 131     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                        | 2,249,355,300.00 | 2,039,296,400.00 | 210,058,900.00  | 90.7  |
| 131001  | Улсын төсвөөс санхүүжих                        | 2,249,355,300.00 | 2,039,296,400.00 | 210,058,900.00  | 90.7  |
| 132     | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                 | 155,293,800.00   | 138,770,960.09   | 16,522,839.91   | 89.4  |
| 132001  | Орон нутгийн төсвөөс                           | 155,293,800.00   | 138,770,960.09   | 16,522,839.91   | 89.4  |
| 120004  | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС          |                  | 5,228,300.00     | (5,228,300.00)  |       |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих      |                  | 5,228,300.00     | (5,228,300.00)  |       |
| 1       | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                | 2,404,649,100.00 | 2,185,516,640.09 | 219,132,459.91  | 90.9  |
| 21      | УРСГАЛ ЗАРДАЛ                                  | 2,404,649,100.00 | 2,171,325,397.45 | 233,323,702.55  | 90.3  |
| 210     | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                | 2,295,809,700.00 | 2,068,314,547.45 | 227,495,152.55  | 90.1  |
| 2101    | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил              | 1,781,517,800.00 | 1,594,558,876.47 | 186,958,923.53  | 89.5  |
| 210101  | Үндсэн цалин                                   | 1,080,150,600.00 | 952,074,121.04   | 128,076,478.96  | 88.1  |
| 210102  | Нэмэгдэл                                       | 640,295,800.00   | 540,233,973.88   | 100,061,826.12  | 84.4  |
| 210103  | Унаа хоолны хөнгөлөлт                          |                  | 40,625,000.00    | (40,625,000.00) |       |
| 210104  | Урамшуулал                                     | 61,071,400.00    | 61,625,781.55    | (554,381.55)    | 100.9 |
| 2102    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 222,689,700.00   | 190,952,207.96   | 31,737,492.04   | 85.8  |
| 210201  | Тэтгэврийн даатгал                             | 151,429,000.00   | 129,289,840.56   | 22,139,159.44   | 85.4  |
| 210202  | Тэтгэмжийн даатгал                             | 17,815,200.00    | 16,225,218.80    | 1,589,981.20    | 91.1  |
| 210203  | ҮОМШӨ-ний даатгал                              | 8,907,600.00     | 8,025,489.46     | 882,110.54      | 90.1  |
| 210204  | Ажилгүйдлийн даатгал                           | 8,907,600.00     | 7,370,998.98     | 1,536,601.02    | 82.8  |
| 210205  | Эрүүл мэндийн даатгал                          | 35,630,300.00    | 30,040,660.16    | 5,589,639.84    | 84.3  |
| 2103    | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал      | 131,293,800.00   | 114,770,960.09   | 16,522,839.91   | 87.4  |
| 210301  | Гэрэл, цахилгаан                               | 19,342,800.00    | 10,288,084.02    | 9,054,715.98    | 53.2  |

|        |  |                  |                  |                  |       |
|--------|--|------------------|------------------|------------------|-------|
| 210302 | Түлш, халаалт  | 103,611,000.00   | 101,180,176.07   | 2,430,823.93     | 97.7  |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 8,340,000.00     | 3,302,700.00     | 5,037,300.00     | 39.6  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 24,000,000.00    | 24,000,000.00    |                  | 100.0 |
| 210604 | Урсгал засвар  | 24,000,000.00    | 24,000,000.00    |                  | 100.0 |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 38,934,500.00    | 43,311,807.93    | (4,377,307.93)   | 111.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,228,300.00     | 5,228,300.00     |                  | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 33,706,200.00    | 38,083,507.93    | (4,377,307.93)   | 113.0 |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 97,373,900.00    | 100,720,695.00   | (3,346,795.00)   | 103.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 86,304,600.00    | 86,964,895.00    | (660,295.00)     | 100.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 11,069,300.00    | 13,755,800.00    | (2,686,500.00)   | 124.3 |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 108,839,400.00   | 103,010,850.00   | 5,828,550.00     | 94.6  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 108,839,400.00   | 103,010,850.00   | 5,828,550.00     | 94.6  |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал                             | 108,839,400.00   | 103,010,850.00   | 5,828,550.00     | 94.6  |
| 222001 | Тоног төхөөрөмж  |                  | (12,395,395.00)  | 12,395,395.00    |       |
| 223001 | Бусад хөрөнгө  |                  | 12,395,395.00    | (12,395,395.00)  |       |
| 2      | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН  | 2,404,649,100.00 | 2,171,325,397.45 | 233,323,702.55   | 90.3  |
| 31     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     |                  | 204,736,591.84   | (204,736,591.84) |       |
| 31     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                    |                  | 218,927,834.48   | (218,927,834.48) |       |
| 1      | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                                     |                  |                  |                  |       |
| 2      | БАЙГУУЛЛАГЫН ТОО   |                  |                  |                  |       |
| 5      | АЖИЛЛАГСДЫН ТОО  |                  |                  |                  |       |
| 24     | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ  |                  |                  |                  |       |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 33,180.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- *Тайлант онд 1-р улирлын 33,180.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан,*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга”-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...”, санхүүгийн тайлангийн “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **131,883.6** мянган төгрөгийн 7 зөрчил<sup>1</sup> илэрснээс 764.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 7,874.7 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 123,244.4 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **8,639.2** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,506.2 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### **3.1 Төлбөрийн акт**

1. Тооцооллын алдаанаас шалтгаалж 2 ажилтанд орон нутгийн нэмэгдэл цалинг давхардуулан бодсоноос 764.5 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 14 ажилтанд 2,398.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах зардлаас 304.1 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл бэлтгэн зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* Боловсролын сайдын 2024 оны А/279 тушаалын 6 дугаар хавсралтын 2.1 *“... ерөнхий боловсролын сургуулийн захирал нь багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулахдаа 1.3-т заасан эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг төлөвлөн хэрэгжүүлнэ”, 2.2 “... эрүүл мэндийн үйлчилгээний зориулалтаар батлагдсан төсөвт багтаан зохион байгуулна”, 2.3 “төсвийн шууд захирагч нь энэхүү зааврын 2.6.2-т заасан эрүүл мэндийн байгууллагатай багш, ажилтны эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоог тухайн ондоо багтаан хийлгэх гэрээ байгуулна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр 3 албан хаагчийн 1,350.4 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд буруу тайлагнаж, 11 дүгээр сарын хоол, унааны хөнгөлөлтийн 4,460.0 мянган төгрөгийн цалинг НДШ -д тайлагнаагүйгээс 3,822.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө*

хянан, баталгаажуулах” Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлан тооцоог хянаж, зөв дүнгээр тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 52 нэр төрлийн 92,812.1 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10.38 (ж) “илүүдэл эд хөрөнгө болон элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоосон тохиолдолд хөрөнгийг данснаас хасаж, уг тогтоосон үнээр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрнө. Мөн уг хөрөнгийн цаашид ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоож, элэгдэл байгуулна” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн ашиглах хугацааг сунган бүртгэл тайланд тусгах зөвлөмж хүргүүллээ.

1.2 Илрүүлэлт: Гүйлгээ баланс дахь хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 20,182.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

#### **2. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

2.1 Илрүүлэлт: Тухайн байгууллагын эзэмшилд буй 1 газрын хэмжээ нь газрын гэрчилгээнд 5450 м<sup>2</sup> гэж бүртгэгдсэн боловч санхүүгийн тайланд 7500 м<sup>2</sup> буюу

зөрүүтэй бүртгэгдсэн байна. Мөн Мандал сумын Засаг даргын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн А/424 дүгээр захирамжаар 1710м2 газрыг тус сургуульд эзэмшүүлсэн боловч уг газрыг үнэлгээ хийлгээгүй, балансад тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга                                      | Нийт алдаа |                 | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                 | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |                 |              |     | Зөвлөмж |     |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----------------|--------------------------|-----|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
|  | Тоо        | Дүн             | Тоо                               | Дүн             | Тоо                      | Дүн | Залруулсан |                 | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|  |            |                 |                                   |                 |                          |     | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн |         |     |
| Үр дүнгийн тайланд элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан | 1          | 33,180.0        | 1                                 | 33,180.0        |                          |     | 1          | 33,180.0        |              |     |         |     |
| <b>Дүн</b>   | <b>1</b>   | <b>33,180.0</b> | <b>1</b>                          | <b>33,180.0</b> |                          |     | <b>1</b>   | <b>33,180.0</b> |              |     |         |     |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                  | Нийт зөрчил |         | Үүнээс        |       |                 |         |         |     |                                      |     |   |     |
|---|-------------|---------|---------------|-------|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
|   | Тоо         | Дүн     | Төлбөрийн акт |       | Албан шаардлага |         | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|   |             |         | Тоо           | Дүн   | Тоо             | Дүн     | Тоо     | Дүн | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| Тооцооллын алдаанаас цалинг давхардуулан олгосон    | 1           | 764.5   | 1             | 764.5 |                 |         |         |     |                                      |     |   |     |
| Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг | 1           | 2,398.1 |               |       | 1               | 2,398.1 |         |     |                                      |     |   |     |

|   |          |                  |          |              |          |                |          |                  |  |  |  |  |
|---|----------|------------------|----------|--------------|----------|----------------|----------|------------------|--|--|--|--|
| давхардуулан бодож олгосон  |          |                  |          |              |          |                |          |                  |  |  |  |  |
| Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношлогоонд хамруулах зардлаас эм, эмийн хэрэгсэл бэлтгэн зориулалт бусаар зарцуулсан | 1        | 304.1            |          |              | 1        | 304.1          |          |                  |  |  |  |  |
| Өмнөх зөвлөмжийг НД тайланд код буруу, 11 сарын унаа хоолны хөнгөлөлтийг НД тайланд тайлагнаагүй                  | 1        | 5172,5           |          |              | 1        | 5172,5         |          |                  |  |  |  |  |
| Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй   | 1        | 92,812.1         |          |              |          |                | 1        | 92,812.1         |  |  |  |  |
| Гүйлгээ баланс, дэлгэрэнгүй тайлангийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл зөрүүтэй                            |          |                  |          |              |          |                | 1        | 20,182.3         |  |  |  |  |
| Биет бус хөрөнгийн бүртгэлд 7500м2 хэмжээтэй 1 газар бүртгэлтэй боловч газрын гэрчилгээгээр 5450 м2 байна         | 1        | 10,250.0         |          |              |          |                | 1        | 10,250.0         |  |  |  |  |
| <b>Дүн</b>  | <b>7</b> | <b>131,883.6</b> | <b>1</b> | <b>764.5</b> | <b>3</b> | <b>7,874.7</b> | <b>3</b> | <b>123,244.4</b> |  |  |  |  |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой   |             |     |               |     |                 |     |         |     |
|  |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Дүн</b>   |             |     |               |     |                 |     |         |     |
| <b>Нийт дүн</b>  |             |     |               |     |                 |     |         |     |

**ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    | Санал дүгнэлтийн хэлбэр |           |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-----------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                         | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй         |           |                |       |                            |
| А | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5                       | 7         | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           |                    |                         | 1         |                |       |                            |
| 2 | Төсөл, хөтөлбөр             |                          |                             |                    |                         |           |                |       |                            |
| 3 | ЗГТС                        |                          |                             |                    |                         |           |                |       |                            |
| 4 | ТТЗ                         |                          |                             |                    |                         |           |                |       |                            |
| 5 | ТЕЗ                         |                          |                             |                    |                         |           |                |       |                            |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    |                    |                         | <b>1</b>  |                |       |                            |